

ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ,
ХӨДӨЛМӨРИЙН БОДЛОГЫН ДОТООД АУДИТ ХАРИУЦСАН АХЛАХ ШИНЖЭЭЧ П.ХОРЛООГИЙН 2024 ОНЫ
СҮҮЛИЙН ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			1	2	3	4	5
Зорилт 1. “Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллага, тусгай сангийн санхүү, үйл ажиллагаанд дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалт хийх, эрсдэлийн удирдлагаар хангах”							
1.	Арга хэмжээ №1.1 Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2022 он, 2023 он болон 2024 оны эхний хагас жилийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийн төлөвлөлт, бүрдүүлэлт, зарцуулалтын үр дүн, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд дотоод аудит хийх.		байхгүй	Илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын Сайдын 2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн “Дотоод аудит хийх тухай” А/18 дугаар тушаалаар баталсан удирдамж, хөтөлбөрийн дагуу ХХҮЕГазрын Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022-2023 он, 2024 оны эхний хагас жилийн орлого, бүрдүүлэлт, зарцуулалтад дотоод аудит хийж гүйцэтгэсэн. Дотоод аудитаар нийтдээ 713.3 сая төгрөгийн асуудал илэрсэн бөгөөд ажлын хариуцлага, дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай зэргийг үндэслэн “САЙЖРУУЛАХ	2024.09.17 2024.10.23	90%

					ШААРДЛАГАТАЙ" дүгнэлт өгсөн.		
2.	Арга хэмжээ №1.2 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах		байхгүй	Зөрчлийг арилгасан байна.	2024 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн "Дотоод аудит хийх тухай" А/18 дугаар тушаалаар баталсан удирдамж, хөтөлбөрийн дагуу ХХҮЕГазар болон ХНХСҮСИ-ийн 2022-2023 он, 2024 оны эхний хагас жилийн шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудасны хөтлөлт, нэгдсэн системд мэдээлэл байршуулсан байдал, тайлагналтад дотоод аудит хийсэн. Дотоод аудитаар дараах зөрчил нийтлэг илэрсэн: - 2023 онд аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, дараа жилийн төсвийн төслийг хугацаа хоцроож мэдээлсэн, - Ажлын байрны төлбөрийн буцаалтад хавсралтаар баримт оруулдаггүй, - Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээ бүрийн тушаал шийдвэрийг хавсралтаар оруулаагүй харин Бусад хэсгийн 5 дах "Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл,	2024.07.01 2024.12.10	100%

				төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” -д ХХҮЕГ-ын даргын тушаал, шийдвэрийг хавсралтаар оруулсан байна. Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 8 дугаар зүйлийн 8.1-д “Шилэн дансанд мэдээлэл тавьсан албан тушаалтан, тухайн асуудал хариуцсан нэгж нь байршуулсан мэдээллээ улирал бүр төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод аудитын албанд дараа сарын 15-ны дотор тайлагнана гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах, алдаа дутагдал давтан гаргасан албан хаагчдад хуульд заасны дагуу хариуцлага тооцож ажиллах талаар ажил хариуцаж байгаа нягтлан бодогч нарт зөвлөгөө, зөвлөмж өгч ажилласан.		
Зорилт 2. “Дотоод аудит, бусад хяналт шалгалтын байгууллагаас өгсөн дүгнэлт, зөвлөмж, тогтоосон акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавих”						
1.	Арга хэмжээ №2.1 Дотоод аудитын хорооны болон удирдлагын		байхгүй		ХНХЯ, ХХҮЕГ, ХНХСҮСИ, ХАБЭМТ–д дотоод аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан	2024.07.01 2024.12.10 90%

	шийдвэрээр тусгайлсан өгсөн үүрэг даалгавар, дотоод аудитаар өгсөн зөвлөмж, тогтоосон акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үнэлгээ хийх.				шаардлагын хэрэгжилтийн биелэлтийг 2020-2024 оны эхний хагас жилийн байдлаар нэгтгэн гаргаж удирдлагад танилцуулахаар бэлтгэж байна.			
2.	Арга хэмжээ № 2.2 Үндэсний аудитын газар бусад хяналт шалгалтын байгууллагын аудит, хяналт шалгалтаар тогтоосон акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавих, үнэлгээ хийх.	Үүрэг тоо	даалгаврын	байхгүй	Зөрчил арилсан байна.	ҮАГ-ын санхүүгийн аудитаар ХХҮЕГ-т өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийн биелэлтийг 2016-2024 оны эхний хагас жилийн байдлаар гаргаж Газрын даргад танилцуулсан. ҮАГ-ын Fas.audit.mn мэдээллийн системд өөрийн хариуцдаг яам, агентлаг болон 11 салбар нэгжийн ҮАГ-аас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэнд чанарын баталгаажуулалтыг цаг хугацаанд нь хийж байна.	2024.07.01 2024.12.10	100%
3.	Арга хэмжээ № 2.3 Хариуцсан салбарын чиг үүргийн хүрээнд хамаарах агентлаг, төсөвт байгууллагын үйл ажиллагаатай холбоотой статистик мэдээ, судалгааны “цахим сан” бүрдүүлэх.			байхгүй	Цахим сан үүснэ.	ХНХЯ, ХХҮЕГ, ХНХСҮСИ, ХАБЭМТ–д дотоод аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтийн биелэлтийг 2020-2024 оны эхний хагас жилийн байдлаар нэгтгэн гаргаж цахим мэдээллийн санг үүсгэж байна. ҮАГ-ын санхүүгийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилтийн биелэлтийг 2016-2024 оны эхний хагас жилийн байдлаар нэгтгэн гаргаж	2024.07.01 2024.12.10	90%

					цахим мэдээллийн санг үүсгэсэн. ХХҮЕГ-ын		
4.	Арга хэмжээ № 2.4 Хариуцсан салбарын чиг үүргийн хүрээнд хууль, эрх зүйн актуудаар "мэдээллийн сан" үүсгэж албан хэрэгцээнд ашиглах.		байхгүй	Мэдээллийн сан үүснэ.	Хариуцсан салбарын чиг үүргийн хүрээнд хууль, эрх зүйн актуудаар "мэдээллийн сан" үүсгэж албан хэрэгцээнд ашиглаж байна.	2024.07.01 2024.12.10	90%

Зорилт 3. Хариуцсан чиг үүргийн хүрээнд хамаарах агентлаг, төсөвт байгууллагын үйл ажиллагаа, хариуцсан албан тушаалтантай холбогдуулан байгууллага, аж ахуй нэгж, иргэдээс ирүүлсэн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг шаардлагатай тохиолдолд шалгах, мэдээлэх, дүнг нэгтгэн удирдлагад танилцуулж хуулийн хугацаанд шийдвэрлэх.

1.	Арга хэмжээ 3.1. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх.	Ирсэн албан бичиг, өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн байна.	Ирсэн өргөдөл, гомдол саналыг судлан танилцуулж мэдээллээр хангаж, хугацаанд нь 100 хувь шийдвэрлүүлсэн байна.	Ирсэн албан бичиг, өргөдөлд гомдолд тухай бүр хугацаанд нь хариу өгөх	Тайлант хугацаанд 4 албан бичиг, 1 өргөдөл хүлээн авч тухай бүр хариу өгч ажилласан.	2024.07.01 2024.12.10	100%
		Холбогдох яам, төрийн байгууллагаас ирүүлсэн албан бичиг, дүрэм журмын төслийг судлан хариу өгөх, тайлбар, танилцуулга бэлтгэн удирдлагад танилцуулсан байна.		Тухай бүр	Сангийн сайдын 2016 оны А/16 дугаар тушаалын дагуу санхүүгийн улсын /ахлах/ байцаагчдын эрхийг цуцлах, эрх олгох тухай 2024 оны 09 сарын 01/375 дугаар бичгийг Сангийн яаманд хүргүүлсэн. Мөн Сангийн сайдын 2024 оны 11 сарын 14-ний өдрийн А/197 дугаар "Журам, загвар шинэчлэн батлах тухай" тушаалын дагуу 2024 оны 12-09-ний өдрийн 12/1537 дугаар албан бичгээр санхүүгийн улсын /ахлах/	2024.07.01 2024.12.10	100%

				байцаагчдын эрхийг сунгуулахаар Сангийн яаманд хүргүүлсэн.		
	Архивын нэгжийг бүрдүүлж хүлээлгэн өгсөн байх.		1	Тайлант хугацаанд ирсэн өргөдөл гомдол, албан бичиг болон дотоод аудит, хяналт шалгалттай холбоотой баримт бичгийг архивын нэгж үүсгэн өгөхөөр бэлтгэж байна.	2024.07.01 2024.12.10	90%

Зорилт 4. “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах”

1.	Арга хэмжээ 4.1. Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх.	Хуульд заасны дагуу хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг, урьдчилсан мэдүүлэг /ХАСХОМ, ХАСУМ/- ийг мэдүүлж, хуулийн хугацаанд баталгаажуулсан байна.	-	ХАСХОМ /ХАСУМ/-ыг хуулийн хугацаанд гаргаж ГБХНХЯ-ны ЭБАТ-нд хянуулан илгээх.	1. ХАСХОМ, ХАСУМ-ийг тус тус хуулийн хугацаанд нь гаргаж ГБХНХЯ-ны ЭБАТ-нд хянуулан, баталгаажуулж илгээсэн. 2. Авлига, ашиг сонирхлын зөрчилгүй ажиллаж, Монгол Улсын Засгийн газраас Авлигатай тэмцэх чиглэлээр хэрэгжүүлж буй цуврал мэдээллийг цахимаар судалж, төрийн албаны ёс зүйг баримтлан, төрийн албаны нэр хүндийг эрхэмлэн ажилласан.	VII/01- XII/15	100%
2.	Арга хэмжээ № 4.2. Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт /хувь/	100%	100%	2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг гаргаж ажилласан.	2024.07.01 2024.12.10	100%

	тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх.						
3.	Арга хэмжээ № 4.3. Удирдлага, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлэх.	Үүрэг даалгаврын тоо	100%	100%	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлж, албан ажилтай холбоотой мэдээ, мэдээллээр хангаж ажилласан. 2024 оны 12/838 дугаар албан бичгээр ХХҮЕГ, ХНХСҮСИ, ХАБЭМТ, түүний харьяа байгууллагуудад хүргүүлж, албан бичигт дурдсан шаардлагатай мэдээллийн авч нэгтгэн, 2025 онд ХШҮДАГ-аас хийх дотоод аудитын төлөвлөгөө боловсруулахад бэлтгэж байна.	2024.07.01 2024.12.30	90%

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Арга хэмжээ 1. Хариуцсан ажлын чиг үүрэгтэй холбоотой мэргэжлийн болон хууль, эрх зүйн мэдлэг чадвараа дээшлүүлэх	Мэргэжлийн болон тасралтгүй боловсролын сургалтад хамрагдаж мэдлэг чадвараа нэмэгдүүлсэн байна.			Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай, Дотоод аудитын болон бусад хууль, эрх зүйн мэдлэг дээшилсэн.	2024.07.01 2024.12.10	85%

2.	Арга хэмжээ 2. “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III”-т Монгол хэлний тухай хуульд зааснаар 2025 оноос төрийн албан хэргийг кирилл болон үндэсний монгол бичгээр хөтлөн явуулах, цаашид бүх нийтээр монгол бичигт шилжих бэлтгэлийг хангах арга хэмжээний хүрээнд Монгол бичиг бие даан сурах.	Монгол бичгээр уншиж, бичиж сурсан байх.	Монгол бичгийн дүрэм, бичиж унших дадлагыг үе шаттай эзэмших. Хүмүүн бичиг сонинг захиалан ашигласан байна.	Монгол бичгийн дүрэм, бичиж унших дадлагын 1-2 дугаар үе шатыг дүүргэх.	Монгол бичгийн дүрмийг судалж, бичиж уншиж сурсан. Хүмүүн бичиг сонинг захиалан уншиж байна.	2024.07.01 2024.12.10	90%
----	---	--	---	---	--	--------------------------	-----

ТАЙЛАН ГАРГАСАН:

АХЛАХ ШИНЖЭЭЧ
(Албан тушаал)

П.ХОРЛОО / П. Хорлоо /
(Нэр, гарын үсэг)

2024-12-13
(Огноо)